



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 9/117

Мандалговь

Эзэмшил газрын зориулалт
өөрчлөх тухай

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг” үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Залуус 1-101 тоотод) байршилтай Онцгой байдлын газар РД:9034129-ын төрийн үйлчилгээний зориулалттай 1010 м² газрыг Нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчилж 20 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгохыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2008 оны 220 тоот захирамж мөн газар эзэмших 0180304 дугаар гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190327